



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор аймгийн Статистикийн хэлтсийн 2018 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн
тайлангийн аудит

Аудитын код: БНА-2019/152/СТА-ТШЗ



Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор
2019 он

Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Цэцэгмаа

Утас: 88089024 Цахим хаяг: tsetsegmaadam@audit.gov.mn

Аудитор: П.Амаржаргал

Утас: 88106992 Цахим хаяг: amar_802002@yahoo.com

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	5
2.1	Оршил	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	8
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11	Шилэн дансны мэдээлэл	9
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
3	Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	10
3.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	10
3.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	10
3.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	12
3.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	13
3.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	14

1 Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Номгон, Баянхонгор сум
Утас, факс 70-44-25-84
E-mail: bayankhongor@audit.gov.mn

БАЯНХОНГОР АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА Х.ГАНЗОРИГ ТАНАА

2019.02.25 № 2/59

танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор аймгийн Статистикийн хэлтсийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баянхонгор аймгийн Статистикийн хэлтсийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор аймгийн Статистикийн хэлтсийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын

D:\Аmагаа\аmагаа\2019\statistik\tailagnal\AM-Статистик Аудитын гэрчилгээ.docx

2519100

систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Баянхонгор аймгийн Статистикийн хэлтсийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Баянхонгор аймгийн Статистикийн хэлтсийн дарга Х.Ганзориг-т танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Статистикийн хэлтсийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Статистикийн хэлтсийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 01 дүгээр сарын 31-наас 2019 оны 02 дугаар сарын 01-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 18-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын аудитор П.Амаржаргал хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор аймгийн Статистикийн хэлтсийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2019 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 03 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Баянхонгор аймгийн Статистикийн хэлтсийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Баянхонгор аймгийн Статистикийн хэлтсийн нь “ Улс төрийн аливаа нөлөөнд автахгүйгээр эдийн засаг, нийгэм, хүн ам зүйн талаарх шинжлэх ухааны арга зүйгээр тооцсон, статистик үнэн бодит мэдээлэл, судалгаагаар төр, засаг, иргэн, байгууллагад адил тэгш үйлчлэхэд оршино” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Баянхонгор аймгийн Статистикийн хэлтсийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Статистикийн мэдээллийн нэгдсэн санг боломжит бүх хэлбэрээр сум, багийн түвшинд сайжруулан байгуулах чиглэл гарган ажиллажээ.

Баянхонгор аймгийн Статистикийн хэлтсийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль

- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй болно.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Баянхонгор аймгийн Статистикийн хэлтсийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд 41 буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Баянхонгор аймгийн Статистикийн хэлтсийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ийн "Acolous" программ хангамж ашигладаг байна.

Баянхонгор аймгийн Статистикийн хэлтсийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд "Дунд" гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Баянхонгор аймгийн Статистикийн хэлтсийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 6 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 6 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг

баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь улсын төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын хувьд байгууллагын нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзсэнтэй холбоотой юм.

Баянхонгор аймгийн Статистикийн хэлтсийн 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 175,5 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 3,5 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын төвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын төвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 6 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд алдаа, зөрчилтэйд тооцох асуудал гараагүй болно.

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Байхгүй

2.8.1.1

Байхгүй

2.8.1.2

Байхгүй

2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Байхгүй

2.10 ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Баянхонгор аймгийн Статистикийн хэлтсийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 77,2 сая төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 3.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 77,2 сая төгрөг буюу 100 хувьтай байгаа нь 2018 онд 77,2 сая төгрөгийн санхүүжилт авч урсгалд үйл ажиллагааны зардал зарцуулсан байна.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Баянхонгор аймгийн Статистикийн хэлтсийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно. Шилэн дансанд байршуулах ёстой мэдээллийг бүрэн оруулсан байгаа боловч төсөв гүйцэтгэлтэй холбоотой мэдээллийн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний тухай бүр оруулах мэдээллийг 6-9 саруудад хугацаа хоцорсон, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалттай холбоотой мэдээллийн хугацаанд нь бүрэн оруулсан, бусад мэдээллийн Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр (Тухай бүр) оруулах гэсэн мэдээллийг 8-р сард, Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан (Бүтэн жилээр) оруулах мэдээллүүдийг тус бүр хугацаандаа оруулаагүй байна.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баянхонгор аймгийн Статистикийн хэлтсийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Баянхонгор аймгийн Статистикийн хэлтсийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

3 Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,753,604.10</u>	<u>1,815,254.10</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	1,753,604.10	1,815,254.10
35300	Бэлэн бүтээгдэхүүн	1,589,223.00	1,589,223.00
354	Хангамжийн материал	164,381.10	226,031.10
35410	Бичиг хэргийн материал	00.00	61,650.00
35420	Аж ахуйн материал	164,381.10	164,381.10
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>8,493,922.92</u>	<u>4,323,114.33</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	8,493,922.92	4,323,114.33
392	Биет хөрөнгө	8,493,922.92	4,323,114.33
39203	Авто-тээврийн хэрэгсэл	40,000,000.00	40,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-38,333,333.55	-40,000,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	40,995,611.74	40,995,611.74
39206	Хуримтлагдсан элэгдэл	-34,826,903.02	-36,966,573.18
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	7,044,896.00	7,044,896.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-6,386,348.25	-6,750,820.23
39214	Бусад үндсэн хөрөнгө	225,741.00	225,741.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-225,741.00	-225,741.00
39301	Програм хангамж	450,000.00	450,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-450,000.00	-450,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>10,247,527.02</u>	<u>6,138,368.43</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>10,247,527.02</u>	<u>6,138,368.43</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	10,247,527.02	6,138,368.43
512	Хуримтлагдсан үр дүн	10,247,527.02	6,138,368.43
51210	Өмнөх үеийн үр дүн	10,247,527.02	10,247,527.02
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-4,109,158.59
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>10,247,527.02</u>	<u>6,138,368.43</u>

3.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	152,799,594.69	171,433,951.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	152,799,594.69	171,433,951.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	86,527,400.00	77,264,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	84,886,900.00	77,264,100.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	1,640,500.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	56,344,280.00	92,155,907.00

Баянхонгор аймгийн Статистикийн хэлтэс 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	56,344,280.00	92,155,907.00
132002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	6,000,000.00	2,000,000.00
132005	Хөрөнгийн санхүүжилт / орон нутгийн төсөвт байгууллага/	3,888,888.69	00.00
1330	Төсвийн захирагчдаас	9,888,888.69	2,000,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	39,026.00	13,944.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	39,026.00	13,944.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	151,319,712.55	175,543,109.59
21	УРСГАЛ ЗАРДАЛ	148,412,299.55	174,978,763.59
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	148,412,299.55	174,978,763.59
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	66,634,023.00	62,084,698.00
210101	Үндсэн цалин	56,851,785.00	44,232,110.00
210102	Нэмэгдэл	00.00	12,430,950.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,759,191.00	1,781,461.00
210105	Гэрээг ажлын хөлс	5,023,047.00	3,640,177.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,613,094.00	7,436,775.00
210201	Тэтгэврийн даатгал	6,613,094.00	6,346,283.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	41,945.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	83,892.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	8,389.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	956,266.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,224,900.00	2,163,250.00
210401	Бичиг хэрэг	468,560.00	504,720.00
210402	Тээвэр, шатахуун	745,000.00	776,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,011,340.00	862,830.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	19,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,866,000.00	1,650,000.00
210604	Урсгал засвар	2,866,000.00	1,650,000.00
2107	Томилолт, зочны зардал	772,000.00	763,500.00
210702	Дотоод албан томилолт	772,000.00	763,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	64,002,480.00	96,165,232.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	62,839,280.00	94,556,107.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	79,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	96,525.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	138,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	22,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,163,200.00	1,273,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,299,802.55	4,715,308.59
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	544,500.00	544,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	4,755,302.55	4,170,808.59
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,907,413.00	564,346.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,476,776.00	541,944.00

Баянхонгор аймгийн Статистикийн хэлтэс 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	39,026.00	13,944.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,437,750.00	528,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	430,637.00	22,402.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	430,637.00	22,402.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>1,479,882.14</u>	<u>-4,109,158.59</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>1,479,882.14</u>	<u>-4,109,158.59</u>

3.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>147,270,206.00</u>	<u>171,433,951.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>147,270,206.00</u>	<u>171,433,951.00</u>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	84,886,900.00	77,264,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	84,886,900.00	77,264,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	56,344,280.00	92,155,907.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	56,344,280.00	92,155,907.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	6,000,000.00	2,000,000.00
132002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	6,000,000.00	2,000,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	39,026.00	13,944.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	39,026.00	13,944.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>147,270,206.00</u>	<u>171,433,951.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>147,270,206.00</u>	<u>171,433,951.00</u>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<u>144,362,793.00</u>	<u>170,869,605.00</u>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	66,777,839.00	62,084,698.00
210101	Үндсэн цалин	56,995,601.00	44,232,110.00
210102	Нэмэгдэл	00.00	12,430,950.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,759,191.00	1,781,461.00
210105	Гэрээт ажлын хөлс	5,023,047.00	3,640,177.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,175,074.00	7,436,775.00
210201	Тэтгэврийн даатгал	7,175,074.00	6,346,283.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	41,945.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	83,892.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	8,389.00

Баянхонгор аймгийн Статистикийн хэлтэс 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	956,266.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,224,900.00	2,224,900.00
210401	Бичиг хэрэг	468,560.00	566,370.00
210402	Тээвэр, шатахуун	745,000.00	776,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,011,340.00	862,830.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	19,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,866,000.00	1,650,000.00
210604	Урсгал засвар	2,866,000.00	1,650,000.00
2107	Томилолт, зочны зардал	772,000.00	763,500.00
210702	Дотоод албан томилолт	772,000.00	763,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	64,002,480.00	96,165,232.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	62,839,280.00	94,556,107.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	79,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	96,525.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	138,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	22,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,163,200.00	1,273,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	544,500.00	544,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	544,500.00	544,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,907,413.00	564,346.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,476,776.00	541,944.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	39,026.00	13,944.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,437,750.00	528,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	430,637.00	22,402.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	430,637.00	22,402.00

3.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
С01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	52,620,955.55	2,902,823.10	-44,490,305.45	00.00	11,033,473.20
С02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
С03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	52,620,955.55	2,902,823.10	-44,490,305.45	00.00	11,033,473.20
С04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00

Баянхонгор аймгийн Статистикийн хэлтэс 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-788,445.12	00.00	-788,445.12
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00	00.00
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	10,247,527.02	00.00	10,247,527.02
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	10,247,527.02	00.00	10,247,527.02
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-4,109,158.59	00.00	-4,109,158.59
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	6,138,368.43	00.00	6,138,368.43

3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	84,886,900.00	84,456,263.00	77,264,100.00	77,241,698.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	84,886,900.00	84,456,263.00	77,264,100.00	77,241,698.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	82,258,900.00	82,018,513.00	76,736,100.00	76,713,698.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	66,781,700.00	66,777,839.00	62,084,700.00	62,084,698.00
210101	Үндсэн цалин	39,873,500.00	56,995,601.00	40,848,300.00	44,232,110.00
210102	Нэмэгдэл	10,689,600.00	00.00	13,201,200.00	12,430,950.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,289,000.00	4,759,191.00	2,515,200.00	1,781,461.00
210105	Гэрээт ажлын хөлс	10,929,600.00	5,023,047.00	5,520,000.00	3,640,177.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,346,100.00	7,175,074.00	7,450,300.00	7,436,775.00
210201	Тэтгэврийн даатгал	4,722,700.00	7,175,074.00	4,966,800.00	6,346,283.00
210202	Тэтгэмжийн даатгал	655,900.00	00.00	620,900.00	41,945.00

Баянхонгор аймгийн Статистикийн хэлтэс 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210203	ҮОМШӨ-ний даатгал	524,600.00	00.00	496,700.00	83,892.00
210204	Ажилгүйдлийн даатгал	131,200.00	00.00	124,200.00	8,389.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,311,700.00	00.00	1,241,700.00	956,266.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,224,900.00	2,224,900.00	2,224,900.00	2,224,900.00
210401	Бичиг хэрэг	452,900.00	468,560.00	452,900.00	566,370.00
210402	Тээвэр, шатахуун	792,000.00	745,000.00	792,000.00	776,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	846,400.00	1,011,340.00	846,400.00	862,830.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	133,600.00	00.00	133,600.00	19,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,866,000.00	2,866,000.00	1,650,000.00	1,650,000.00
210604	Урсгал засвар	2,866,000.00	2,866,000.00	1,650,000.00	1,650,000.00
2107	Томилолт, зочны зардал	772,200.00	772,000.00	772,200.00	763,500.00
210702	Дотоод албан томилолт	772,200.00	772,000.00	772,200.00	763,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,723,500.00	1,658,200.00	2,009,500.00	2,009,325.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	495,000.00	495,000.00	400,200.00	400,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	00.00	79,200.00	79,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	00.00	96,600.00	96,525.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	55,400.00	00.00	138,000.00	138,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	9,900.00	00.00	22,100.00	22,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,163,200.00	1,163,200.00	1,273,400.00	1,273,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	544,500.00	544,500.00	544,500.00	544,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	544,500.00	544,500.00	544,500.00	544,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,628,000.00	2,437,750.00	528,000.00	528,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,628,000.00	2,437,750.00	528,000.00	528,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,628,000.00	2,437,750.00	528,000.00	528,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	84,886,900.00	84,456,263.00	77,264,100.00	77,241,698.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	84,886,900.00	84,456,263.00	77,264,100.00	77,241,698.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	84,886,900.00	84,456,263.00	77,264,100.00	77,241,698.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	00.00	00.00	06.00	06.00
620001	Удирдах ажилтан	00.00	00.00	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	00.00	00.00	04.00	04.00
620003	Үйлчлэх ажилтан	00.00	00.00	01.00	01.00

Баянхонгор аймгийн Статистикийн хэлтэс 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

632	МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ	07.00	06.00	00.00	00.00
632001	Төрийн өмчит МСҮТ	01.00	01.00	00.00	00.00
632002	Хувийн МСҮТ	04.00	04.00	00.00	00.00
64	ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО	02.00	01.00	00.00	00.00